



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/15

Бат-Өлзий сум

**Шууд худалдан авах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 3.6.9 дэх заалт, Засгийн газрын “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2024 оны төсөв батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтын 22 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хогны менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын худалдан авах ажлыг ажлын хэсгийн 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 02 дугаар хурлын дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн “Өнгө нэм” нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагатай шууд худалдан авах гэрээ байгуулж гүйцэтгүүлсүгэй.

2.“Өнгө нэм” нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3.Хогны менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын худалдан авах зардалд шаардагдах 19,990,900 /арван есөн сая есөн зуун ерэн мянга есөн зуу/ төгрөгийг гэрээний дагуу Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН